



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 48

Мандалговь

Үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 30,000,000 /гучин сая/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 87-25 ДУА улсын дугаартай УАЗ 220695-355 маркийн фургон автомашины худалдах доод үнийг 5000,000 /таван сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Саруулжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөх.

3.2 Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.


3.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
78 дугаар тогтоолын хавсралт



Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Худалдах үнэ
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
3	Фургон автомашин	УАЗ-22069-355	ДУА	87-25	2016	2016.12.12	220695G 0487959	2693	189345	30,000,000	30,000,000	5,000,000
Хөрөнгийн нийт дүн												
										30,000,000		5,000,000 /таван сая/ төгрөг